

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр Хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17-н давхар
Хурал хуралдах өдөр, цаг	2025 оны 4 сарын 30-ны өдөр, 15:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сэнтрал Тауэрийн 17-н давхарт
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2025 оны 3 сарын 19-ний өдөр
Олон нийтэд зарлах огноо	2025 оны 3 сарын 24-ны өдөр
Бүртгэлийн өдөр	2025 оны 4 сарын 9-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2025 оны 3 сарын 28-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2025 оны 3 сарын 21-ний өдөр
Хурлын даргын нэр	Ч.ГАНХУЯГ
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл Тооллогын комиссын гишүүд: Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо	

Хурал зохион байгуулах комиссын дарга



/ Ч.ГАНХУЯГ /

2025.03.20

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 4 сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэрийн 17-н давхарт зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ**.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 сарын 9-ний өдрөөр **ТОГТООСУГАЙ**.
3. Хурлын зарыг 2025 оны 3 сарын 24-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 4 сарын 10-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр **ДАМЖУУЛСУГАЙ**.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 3 сарын 28-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
5. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг **ТОМИЛСУГАЙ**.
6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ**. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Гүйцэтгэх захирал Б.Золбоо

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Ө.Ашхүү;
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Г.Уянга;
Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүн;
Хөрөнгө Оруулалт Хариуцсан захирал Х.Билгүүн;
Ерөнхий нягтлан бодогч Б.Оюунсувд;

7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр Хавсралтаар, Саналын хуудасны загварыг Хоёрдугаар Хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар Хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр Хавсралтаар тус тус **БАТАЛСУГАЙ.**
8. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар **БОЛГОСУГАЙ.**
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ.** Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
 - Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК)
 - Тооллогын комиссын гишүүд:
 - Ч.Даваацэрэн (Ард Секюритиз ҮЦК ХХК)
 - А.Эрхбилгүүн (Ард Секюритиз ҮЦК ХХК)
10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст **ДААЛГАСУГАЙ.**
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ



**2025 ОНЫ 4-Р САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох (саналын хуудас);
7. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай (саналын хуудас);



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4, 6, 7)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
2	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг санал хураалтын дүнгийн дагуу сонгох			
3	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг Хавсралт 1-ийн дагуу батлах			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



**АРД САНХУУГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүд		
1		
2		
3		
4		
5		
6		
7		
Хараат бус гишүүд		
1		
2		
3		
4		

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны

тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй ($100 \times 9 \text{ гишүүн} = 900$) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ...сарын ...-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр 17 давхарт болох тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох (саналын хуудас);
7. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай (саналын хуудас);

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: **2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр** байна.

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч Та бүхэн хуралдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болох ба брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар болон Ард Апп-аар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацаа 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт дуусна.

Мөн Та бүхэн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.ardholdings.com цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд ирж болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбоо барьж авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр 17 давхар

Утас: 77003322, 99588931

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Төлөөлөн Үндирдэх Зөвлөлийн
2025 оны 3-р сарын 19-ний өдрийн
тоот тогтоолын Хавсралт 4

**2025 ОНЫ 4 САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн анкет, танилцуулга;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.